



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/122/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2026 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

Алб. А. Д. № 224
танай Алб. О. Д. ны № 2/10 -т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН
СУМЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ГАНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2-т "Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна", Засгийн газрын 267 тогтоолоор "Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн

2126050054

амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай"- гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Баяндун сумын ЗДТГ нь 2025 онд 5 зорилт, 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 90.1 хувиар үнэлүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	492,814,069.36	432,603,857.75
35	БАРАА МАТЕРИАЛ	492,814,069.36	432,603,857.75
351	Түүхий эд материал	4,443,287.85	8,585,799.35
35110	Тусгай зориулалттай материал	3,626,000.00	3,000,000.00
35130	Эм боох материал	817,287.85	5,585,799.35
35300	Бэлэн бүтээгдэхүүн	53,343,500.00	63,325,500.00
354	Хангамжийн материал	294,931,473.51	220,596,750.40
35410	Бичиг хэргийн материал	2,512,060.00	2,048,356.00
35420	Аж ахуйн материал	214,580,104.01	216,126,584.40
35430	Сэлбэг хэрэгсэл	389,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	3,171,871.00	1,921,810.00
35450	Барилгын засварын материал	500,000.00	500,000.00
35470	Бусад хангамжийн материал	73,778,438.50	21,137,754.59
35600	Мал амьтад	14,095,808.00	14,095,808.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,464,058,619.67	4,064,096,195.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,464,058,619.67	4,064,096,195.31
392	Биет хөрөнгө	3,009,417,096.87	3,752,119,845.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	990,914,838.36	1,795,827,097.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(283,982,611.16)	(406,191,163.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,303,908.00	187,168,424.13
39204	Хуримтлагдсан элэгдэл	(74,378,220.84)	(127,412,871.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	402,826,147.00	189,061,840.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(211,955,054.37)	(101,879,303.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,939,011.50	39,239,011.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,009,461.84)	(34,149,457.94)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,223,569,826.00	1,234,746,764.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(459,928,856.07)	(531,018,983.07)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,265,856,253.00	2,071,743,040.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(347,738,682.71)	(565,014,552.95)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	348,000,000.00	-
393	Биет бус хөрөнгө	454,641,522.80	311,976,350.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(406,250.00)	(781,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	490,642,000.00	348,256,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(37,094,227.20)	(36,998,400.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,956,872,689.03	4,496,700,053.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,956,872,689.03	4,496,700,053.06
51	Засгийн газрын хувь оролцоо	3,956,872,689.03	4,496,700,053.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	919,935,015.24	919,935,015.24
51101	Өмч: - төрийн	919,935,015.24	919,935,015.24
512	Хуримтлагдсан үр дүн	2,594,577,106.60	3,134,404,470.63
51210	Өмнөх үеийн үр дүн	2,039,713,368.10	2,594,577,106.60
51220	Тайлант үеийн үр дүн	554,863,738.50	539,827,364.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	442,360,567.19	442,360,567.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,956,872,689.03	4,496,700,053.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,922,120,819.75	2,120,767,900.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150,000.00	75,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	75,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	633,578,963.00	1,043,062,030.38
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	267,437,884.50	3,665,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,020,953,972.25	1,073,965,870.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,321,672.25	28,140,770.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	33,219,690.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,107,854.25	28,140,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,994,128.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	943,632,300.00	1,045,825,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	943,632,300.00	1,045,825,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,333,744,199.95	1,562,940,536.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,333,744,199.95	1,562,940,536.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,226,649,491.87	1,462,370,140.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,642,140.76	706,581,943.68
210101	Үндсэн цалин	326,307,861.69	405,779,763.73
210102	Нэмэгдэл	184,947,662.41	265,476,835.44
210104	Урамшуулал	30,719,048.75	34,745,539.11
210105	Гэрээт ажлын хөлс	19,667,567.91	579,805.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,923,193.30	88,004,851.31
210201	Тэтгэврийн даатгал	44,893,024.48	58,818,915.91
210202	Тэтгэмжийн даатгал	5,259,987.34	8,005,833.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,317,409.14	3,673,215.76
210204	Ажилгүйдлийн даатгал	2,877,285.45	3,608,430.88
210205	Эрүүл мэндийн даатгал	10,575,486.89	13,898,454.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,289,382.26	21,194,614.60
210301	Гэрэл, цахилгаан	6,329,784.26	7,392,226.60
210302	Түлш, халаалт	12,959,634.00	13,802,388.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	57,776,854.25	49,503,005.61
210401	Бичиг хэрэг	3,761,430.00	4,559,004.00
210402	Тээвэр, шатахуун	37,657,774.25	33,578,216.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,737,920.00	1,894,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,619,730.00	9,471,285.61
2105	Нормативт зардал	33,782,071.60	2,756,948.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,121,000.00	431,488.50
210502	Хоол, хүнс	4,661,071.60	2,325,460.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	12,120,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	380,000.00
210604	Урсгал засвар	-	11,740,200.00
2107	Томилолт, зочны зардал	11,294,200.00	10,690,000.00
210702	Дотоод албан томилолт	11,294,200.00	10,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,958,462.00	13,200,205.00

Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,947,684.00	10,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	255,420.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,000.00	376,944.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	880,000.00	880,000.00
210807	Газрын төлбөр	999,678.00	999,841.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	461,983,187.70	558,318,372.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,612,250.00	126,408,717.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	368,370,937.70	426,909,654.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,094,708.08	100,570,395.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,200,800.00	7,460,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,102,000.00	7,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,098,800.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	65,893,908.08	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,893,908.08	93,110,395.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	588,376,619.80	557,827,364.03
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33,512,881.30	18,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,512,881.30	18,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(33,512,881.30)	(18,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	554,863,738.50	539,827,364.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,040,603,972.25	1,074,040,870.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,650,000.00	75,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,650,000.00	75,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,650,000.00	75,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,650,000.00	75,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,020,953,972.25	1,073,965,870.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,321,672.25	28,140,770.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	33,219,690.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,107,854.25	28,140,770.00
131106	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	943,632,300.00	1,045,825,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	943,632,300.00	1,045,825,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	985,294,770.25	1,074,040,870.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	985,294,770.25	1,074,040,870.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	878,200,062.17	973,470,474.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,642,140.76	706,581,943.68
210101	Үндсэн цалин	326,307,861.69	405,779,763.73
210102	Нэмэгдэл	184,947,662.41	265,476,835.44
210104	Урамшуулал	30,719,048.75	34,745,539.11
210105	Гэрээт ажлын хөлс	19,667,567.91	579,805.40

Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,791,193.30	88,004,851.31
210201	Тэтгэврийн даатгал	44,761,024.48	58,818,915.91
210202	Тэтгэмжийн даатгал	5,259,987.34	8,005,833.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,317,409.14	3,673,215.76
210204	Ажилгүйдлийн даатгал	2,877,285.45	3,608,430.88
210205	Эрүүл мэндийн даатгал	10,575,486.89	13,898,454.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,476,584.26	21,194,614.60
210301	Гэрэл, цахилгаан	6,329,748.26	7,392,226.60
210302	Түлш, халаалт	18,146,836.00	13,802,388.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,988,458.25	37,223,118.00
210401	Бичиг хэрэг	3,394,180.00	3,177,850.00
210402	Тээвэр, шатахуун	31,525,668.25	22,528,678.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,737,920.00	2,276,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,330,690.00	9,240,140.00
2105	Нормативт зардал	1,017,500.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,017,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,089,900.00	16,875,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,821,500.00	5,475,550.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	400,000.00
210604	Урсгал засвар	3,268,400.00	11,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,479,200.00	10,690,000.00
210702	Дотоод албан томилолт	11,479,200.00	10,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,958,462.00	13,200,205.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,947,684.00	10,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	255,420.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,000.00	376,944.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	880,000.00	880,000.00
210807	Газрын төлбөр	999,678.00	999,841.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,756,623.60	79,700,192.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,756,623.60	74,700,192.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,094,708.08	100,570,395.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,200,800.00	7,460,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,102,000.00	7,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,098,800.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	65,893,908.08	93,110,395.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,893,908.08	93,110,395.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>55,309,202.00</u>	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	55,309,202.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	919,935,015.24	442,360,567.19	2,039,713,368.10	3,402,008,950.53
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	919,935,015.24	442,360,567.19	2,039,713,368.10	3,402,008,950.53
Тайлант үеийн үр дүн	-	-	554,863,738.50	554,863,738.50

Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	919,935,015.24	442,360,567.19	2,594,577,106.60	3,956,872,689.03
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	919,935,015.24	442,360,567.19	2,594,577,106.60	3,956,872,689.03
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	919,935,015.24	442,360,567.19	2,594,577,106.60	3,956,872,689.03
Тайлант үеийн үр дүн	-	-	539,827,364.03	539,827,364.03
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	919,935,015.24	442,360,567.19	3,134,404,470.63	4,496,700,053.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,075,973,000.00	1,074,040,870.00	1,932,130.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,075,973,000.00	1,074,040,870.00	1,932,130.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	973,740,474.59	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,391,100.00	706,851,943.68	81,539,156.32
210101	Үндсэн цалин	421,930,000.00	406,359,569.13	15,570,430.87
210102	Нэмэгдэл	326,414,100.00	265,746,835.44	291,668,560.89
210104	Урамшуулал	40,047,000.00	34,745,539.11	5,301,460.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,889,100.00	88,004,851.31	10,544,248.69
210201	Тэтгэврийн даатгал	67,241,800.00	58,818,915.91	8,422,884.09
210202	Тэтгэмжийн даатгал	8,211,200.00	8,005,833.93	205,366.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,834,500.00	3,673,215.76	161,284.24
210204	Ажилгүйдлийн даатгал	3,834,500.00	3,608,430.88	226,069.12
210205	Эрүүл мэндийн даатгал	15,767,100.00	13,898,454.83	1,868,645.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,582,900.00	21,194,614.60	(611,714.60)
210301	Гэрэл цахилгаан	6,537,900.00	7,392,226.60	(854,326.60)
210302	Түлш халаалт	14,045,000.00	13,802,388.00	242,612.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,617,900.00	37,223,118.00	(6,605,218.00)
210401	Бичиг хэрэг	3,097,900.00	3,177,850.00	(79,950.00)
210402	Тээвэр шатахуун	20,000,000.00	22,528,678.00	(2,528,678.00)
210403	Шуудан холбоо интернэт	2,520,000.00	2,276,450.00	243,550.00
210406	БҮТЭ аж ахуйн материал	5,000,000.00	9,240,140.00	(4,240,140.00)
2106	Урсгал засварын зардал	18,900,000.00	16,875,550.00	2,024,450.00
210601	Багаж хэрэгсэл	5,500,000.00	5,475,550.00	24,450.00
210603	хөдөлмөр хамгаалал	400,000.00	400,000.00	-
210604	Урсгал засварын	13,000,000.00	11,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочин зардал	11,600,000.00	10,690,000.00	910,000.00
210702	Дотоод албан томилолт	11,600,000.00	10,690,000.00	910,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,550,000.00	13,200,205.00	(6,650,205.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	10,600,000.00	(8,100,000.00)
210802	Аудит	380,000.00	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	255,420.00	244,580.00
210804	ТХэрэгслийн татвар	600,000.00	376,944.00	976,944.00
210805	ТХэрэгслийн оношилгоо	250,000.00	88,000.00	162,000.00

210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,320,000.00	880,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	999,841.00	159.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,682,000.00	79,700,192.00	12,981,808.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,682,000.00	74,700,192.00	12,981,808.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	5,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		100,570,395.41	
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,760,000.00	7,460,000.00	300,000.00
213208	Хөдөө орон нутгийн тэтгэмж	7,260,000.00	7,260,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	200,000.00	300,000.00
			93,110,395.41	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,075,973,000.00	1,074,040,870.00	1,932,130.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,004,373,000.00	-	-
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	-	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	71,000,000.00	-	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Завсрын аудитаар нийт 548.9 сая төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэж завсрын аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан 238.1 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Санхүүгийн тайлангийн толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэж залруулав.
- Үндсэн хөрөнгө дансанд капиталжуулах өртгийн 304.7 сая төгрөгийн хөрөнгийг ангилал зөрүүтэй бусад хөрөнгөөр бүртгэж тайлагнасан нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Санхүүгийн тайлангийн толилуулга”

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэж залруулав.

- Бараа материал дансанд бүртгэлтэй 3.7 сая төгрөгийн бараа материалын ангиллыг өөрчилж залруулав. Энэ нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Санхүүгийн тайлангийн толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул залруулав.
- Цалин нийт зардал, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлангийн тайлагнасан дүнг 3.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур журмын 4.1.3-т “Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх” 4.1.5.Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх” гэсэнтэй нийцэхгүй байсныг залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 6,261,9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9,367.5 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 6.2 сая төгрөгийн зөрчил² 4 илэрснээс 5.7 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.5 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Зардлыг анхан шатны баримттай тулгахад шатахууны зардлыг дээд шатны байгууллагаас баталсан жишиг нормтой тулган хяналт хийгээгүй, зардлыг хэтрүүлэн 4,140,911 төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Зам, тээвэр хөгжлийн яамны 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралт “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-д заасантай нийцэхгүй байна.
2. ХАА хариуцсан мэргэжилтэн Б.Бадамхандад 5 жилийн тэтгэмж 7,260,000 төгрөгийг олгосон ба ХХОАТ-ын 10% болох 726,000 төгрөгийг суутгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 7 дугаар зүйлийн 7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна: 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого:

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

25.6. Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ. Татварын ерөнхий хуулийн 6.1.19. "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг" хэлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

3. Нохой устгалын 870.0 мянган төгрөгийн зардлыг анхан шатны баримт бүрдүүлэлт дутуу, гэрээ байгуулж, зарлагын хяналт хийлгүй олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Орлогын биелэлтийн асуудал

Илрүүлэлт: Сумын ИТХ-аар баталсан төсөвтэй хамт тайлант жилийн орлогын төлөвлөгөө батлагддаг бөгөөд тухайн жил 600,000 төгрөгөөр төлөвлөгдсөн боловч гүйцэтгэлээр 75,000 төгрөгийн орлого олж, 525,000 төгрөг буюу 87.5 хувиар биелэгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын биелэлтийг хангаж ажиллах;

2. Хууль, тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2-т "Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна", Засгийн газрын 267 тогтоолоор "Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай" гэсэнтэй нийцэхгүй байна. УИХ-ын 48 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдыг чадавхжуулах, чиг үүргийн давхардлыг арилгахад чиглэгдсэнд арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тогтоолын хэрэгжилтийг хангаж чиг үүргийн давхардлыг арилгаж ажиллах;

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	238,133.7					1	238,133.7				
Капиталжуулах үндсэн хөрөнгийг бусад хөрөнгө данснаас ангилал шилжүүлсэн	1	304,771.6					1	304,771.6				
Бараа материалын ангилал зөрүүтэй бүртгэлийг зассан	1	3,726.0					1	3,726.0				
Цалин, НД, ХХОАТ-ын тайлангийн зөрүү	1	3,305.2					1	3,305.2				
Дүн	4	549,936.6					4	549,936.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зарцуулалтыг норм, нормативаас хэтрүүлэн олгосон	1	4,140.9			1	4,140.9						
5 жилийн тэтгэмжээс ХХОАТ суутган тооцоогүй	1	726.0			1	726.0						
Анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй зардал гаргасан	1	870.0			1	870.0						
Орлого дутуу төвлөрүүлсэн	1	525.0					1	525.0				
Дүн	4	6,261.9			3	5,736.9	1	525.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны 171 мэдээнээс 164 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа хоцроосон 2, мэдээлээгүй 5	1	842,091.0					1	842,091.0	

Дорнод аймгийн Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

мэдээлэл байна. 5.0 төгрөгнөөс дээш орлогын 42 гүйгээний 832,091,000 төгрөг, зарлагын 1 гүйлгээ 10,000,000 төгрөгийн гүйлгээг мэдээллээгүй байна.								
УИХ-ын 48 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна	1	-					1	-
Нийт дүн	1	842,091.0			1	842,091.0	1	-